



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2024/43/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:  
[www.Umnugovi@audit.mn](mailto:www.Umnugovi@audit.mn)  
Өмнөговь аймаг  
Даланзадгад сум  
2024 он

Өмнөговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор:  
Ц.Өсөхбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn  
Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn  
Ахлах аудитор: С.Одончимэг  
Утас: 70533552 Цахим хаяг: Odonchimegs@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2024.08.15 № 249  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

"ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН  
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Т.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

"ДҮТ" ТӨХК-аас худалдаж авах цахилгаан эрчим хүчний үнэ тариф нэмэгдсэнээр алдагдал хүлээж өмнөх саруудад төлсөн татварын төлөлттэй холбоотойгоор оны эцэст 524.9 сая төгрөгийн ААНОАТ, 448.7 сая төгрөгийн НӨАТ-ын авлага үүссэн байна.

#### Аудитын гол асуудал

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК тайлант онд гүйцэтгэлээр 53,118.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэн 52,826.1 сая төгрөгийн зарцуулж 254.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

#### Бусад асуудлын хэсэг

Тус компани нь 2022 оны аудит хийсэн санхүүгийн тайлан тэнцлээр алдагдалтай ажилласан тул Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 04 дүгээр тогтоолын дагуу 2023 онд ногдол ашиг хуваарилаагүй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

016020451

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	<b>ХӨРӨНГӨ</b>		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	231,756,523.16	23,487,285.80
1.1.2	Дансны авлага	955,187,329.41	852,038,712.01
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	170,196,864.01	975,772,535.42
1.1.6	Бараа материал	125,782,882.64	116,889,597.44
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	399,999.86	149,999.79
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	52,107,681.78	52,107,681.78
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,535,431,280.87</b>	<b>2,020,445,812.24</b>
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	16,198,105,607.60	15,879,327,893.40
1.2.2	Биет бус хөрөнгө	823,257,195.71	841,202,067.70
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>17,021,362,803.31</b>	<b>16,720,529,961.10</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>18,556,794,084.18</b>	<b>18,740,975,773.34</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
2.1	<b>Өр төлбөр</b>		
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	6,585,445.23	51,522,287.98
2.1.1.2	Цалингийн өглөг	(0.00)	0.00
2.1.1.3	Татварын өр	101,029,301.49	211,327.50
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.00	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	42,400,186.40	43,043,714.73
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	26,329,486.00	31,997,475.50
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>176,344,419.12</b>	<b>126,774,805.71</b>
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	375,440,000.00	335,920,000.00
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>375,440,000.00</b>	<b>335,920,000.00</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>551,784,419.12</b>	<b>462,694,805.71</b>
2.3	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	17,141,059,974.16	17,141,059,974.16
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	681,771,461.65	681,771,461.65
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	881,049,485.25	899,663,485.25
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(698,871,256.00)	(444,213,953.43)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>18,005,009,665.06</b>	<b>18,278,280,967.63</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>18,556,794,084.18</b>	<b>18,740,975,773.34</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	25,100,763,949.83	52,379,455,654.41
2	Борлуулалтын өртөг	24,482,760,434.78	50,106,286,303.38
3	Нийт ашиг (алдагдал)	618,003,515.04	2,273,169,351.03
4	Түрээсийн орлого		-
5	Хүүний орлого	-	3,973,363.85
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	577,026,192.39	734,648,090.93
9	Борлуулалт, маркетингийн зардал	22,197,545.46	25,654,670.92
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,164,777,018.81	2,483,023,721.86
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	342,805,545.83	211,124,350.52
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,334,750,402.66)	291,988,062.50
19	Орлогын татварын зардал	-	37,330,759.95
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,334,750,402.66)	254,657,302.55
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,334,750,402.66)	254,657,302.55
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	(1,334,750,402.66)	254,657,302.55
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	16,845,740,900.16	681,771,461.65	1,176,368,559.25	746,529,146.67	19,450,410,067.73
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	5,000,000.00	5,000,000.00
Залруулсан үлдэгдэл	16,845,740,900.16	681,771,461.65	1,176,368,559.25	751,529,146.67	19,455,410,067.73
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(1,334,750,402.66)	(1,334,750,402.66)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	295,319,074.00	-	(295,319,074.00)	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	(115,650,000.00)	(115,650,000.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	17,141,059,974.16	681,771,461.65	881,049,485.25	(698,871,256.00)	18,005,009,665.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	0.01	0.01
Залруулсан үлдэгдэл	17,141,059,974.16	681,771,461.65	881,049,485.25	(698,871,255.99)	18,005,009,665.07
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	254,657,302.55	254,657,302.55
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	18,614,000.00	-	18,614,000.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
23 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	17,141,059,974.16	681,771,461.65	899,663,485.25	(444,213,953.44)	18,278,280,967.62

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	25,108,211,489.51	53,591,787,865.16
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	24,469,549,828.57	52,630,038,907.78
	Бусад мөнгөн орлого	638,661,660.93	961,748,957.38
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	24,877,111,233.92	53,068,233,332.87
	Ажиллагчдад төлсөн	2,334,507,066.91	2,668,994,238.09
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	750,692,258.43	855,737,226.31
	Бараа материал худалдан авахад төлсөн	19,507,674,110.31	45,663,826,696.31
	Ашиглалтын зардалд төлсөн	3,956,801.00	4,380,400.91
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	65,650,663.36	72,732,000.42
	Хүүний төлбөрт төлсөн	3,952,000.00	3,655,600.00
	Татварын байгууллагад төлсөн	639,554,419.45	2,756,842,919.54
	Даатгалын төлбөрт төлсөн	12,649,963.66	13,948,116.28
	Бусад мөнгөн зарлага	1,558,473,950.80	1,028,116,135.01
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	231,100,255.58	523,554,532.29
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	289,112.00	4,256,337.85
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	289,112.00	282,974.00
	Хүлээн авсан хүүний орлого	-	3,973,363.85
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	236,695,014.12	696,560,107.50
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	236,695,014.12	686,560,107.50
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	10,000,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(236,405,902.12)	(692,303,769.65)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	155,170,000.00	39,520,000.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	39,520,000.00	39,520,000.00
	Төлсөн ногдол ашиг	115,650,000.00	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(155,170,000.00)	(39,520,000.00)
4.1	Валютын ханшийн зөрүү	-	-
4.2	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(160,475,646.53)	(208,269,237.36)
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	392,232,169.69	231,756,523.16
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	231,756,523.16	23,487,285.80

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	2022 оны мөн үе	2023 оны		Зөрүү	Хувь
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>Худалдаж авсан цахилгаан</b>		<b>сая кВт.ц</b>	<b>133.6</b>	<b>154.2</b>	<b>215.2</b>	<b>61.0</b>	<b>139.6</b>
	Түгээлтийн алдагдал	хувиар	хувь	16.6	10.2	8.7	(1.5)	85.7
		биетээр	сая кВт.ц	22.1	15.7	18.8	3.1	119.6
<b>Борлуулах цахилгаан эрчим хүч</b>		<b>сая кВт.ц</b>	<b>111.5</b>	<b>138.5</b>	<b>196.4</b>	<b>57.9</b>	<b>141.8</b>	
<b>Нийт орлого</b>			<b>сая төг</b>	<b>25,677.8</b>	<b>34,739.2</b>	<b>53,118.1</b>	<b>18,378.9</b>	<b>152.9</b>
2	Үүнээс:	Борлуулалтын орлого	сая төг	21,078.0	29,775.5	47,349.0	17,573.5	159.0
		Түгээх үйлчилгээний төлбөр	сая төг	4,022.8	4,722.8	5,030.5	307.7	106.5
		Үйл ажиллагааны бус орлого	сая төг	577.0	240.9	738.6	497.7	306.6
<b>Нийт зардал</b>			<b>сая төг</b>	<b>27,012.5</b>	<b>35,911.2</b>	<b>52,826.1</b>	<b>16,914.9</b>	<b>147.1</b>
3	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	сая төг	5,222.0	6,478.3	6,356.9	(121.4)	98.1
		Худалдаж авсан ЦЭХ-ний өртөг	сая төг	21,537.8	29,250.8	46,325.1	17,074.3	158.4
		Үйл ажиллагааны бус зардал	сая төг	252.8	182.1	144.1	(38.0)	79.1
4	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/		сая төг	(1,334.8)	(1,172.0)	292.0	1,464.0	- 24.9
5	Татварын дараах ашиг /алдагдал/		сая төг	(1,334.8)	(1,172.0)	254.7	1,426.7	- 21.7
6	Борлуулалтын 1 төг-т ногдох зардал		төгрөг	1.05	1.03	0.99	(0.0)	96.2
<b>Нийт авлага</b>			<b>сая төг</b>	<b>1,125.4</b>	<b>1,139.6</b>	<b>1,827.8</b>	<b>688.2</b>	<b>160.4</b>
7	Үүнээс:	ЦЭХ-ний	сая төг	611.3	545.6	509.5	(36.1)	93.4
		Бусад	сая төг	514.1	594.0	1,318.3	724.3	221.9
<b>Нийт өр төлбөр</b>			<b>сая төг</b>	<b>551.8</b>	<b>452.9</b>	<b>462.7</b>	<b>9.8</b>	<b>102.2</b>
8	Үүнээс:	Урт хугацаат	сая төг	375.4	335.9	335.9	-	100.0
		Богино хугацаат	сая төг	176.3	117.0	126.8	9.8	108.4
9	Нийт ажилчдын тоо		тоо	97.0	104.0	100.0	(4.0)	96.2
10	Цалингийн сан		сая төг	2,809.4	3,421.4	3,193.7	(227.7)	93.3
11	Цахилгаан тасалдлын дундаж хугацаа И-сайд и		цаг	18.1	66.5	65.5	(1.0)	98.6
12	ТЗБАХ, Хөрөнгө оруулалт, их засвар		сая төг	517.7	797.0	771.9	(25.1)	96.8

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй байна.

Аудитаар нийт 81.6 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 81.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй байна.

#### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй байна.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Тус компани нь 2023 оны санхүүгийн тайлангаа 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн албан бичгээр 02 дугаар сарын 20-ны өдөр Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д *"Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх"* гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмчит хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлж байх

Илрүүлэлт 2: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, "Тасалж, залгах хэрэгсэл нийлүүлэх гэрээ 2023/37", "Хөдөлмөр хамгааллын зуны хувцас нийлүүлэх гэрээ 2023/39", "Зуны гутал нийлүүлэх 2023/41", "Эмэгтэйчүүдийн зуны хувцас нийлүүлэх 2023/46", "Ажилтнуудын хувцас ажлын хувцас нийлүүлэх 2023/52", "Хөдөлмөр хамгааллын өвлийн хувцас нийлүүлэх 2023/78", "Өвлийн гутал нийлүүлэх гэрээ 2023/79 тоот гэрээг тус тус хэсэгчлэн байгуулж, худалдан авалт хийж ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д *"Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно"*, 48 дугаар зүйлийн 48.1-д *"Захиалагч худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг шаардлагатай бол техник, эдийн засгийн үндэслэлийн хамт дараа жилийн төсвийн төсөлтэй хамтад нь боловсруулж, харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ"* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох, зөрчлийг давтан гаргахгүй байх, худалдан авах ажиллагааны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

Илрүүлэлт 3: Тухайн онд худалдан авсан барааг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт гаргаагүй, "Сорос компьютер" ХХК-тай шууд гэрээ байгуулж компьютер тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д *"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний*

---

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй байна.*

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж, цахим дэлгүүрт байршсан бараа үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус компани нь 2023 оны санхүүгийн тайлангаа 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн албан бичгээр 02 дугаар сарын 20-ны өдөр Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна	1	0					1	0				
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, "Тасалж, залгах хэрэгсэл нийлүүлэх гэрээ 2023/37", "Хөдөлмөр хамгааллын зуны хувцас нийлүүлэх гэрээ 2023/39", "Зуны гутал нийлүүлэх 2023/41", "Эмэгтэйчүүдийн зуны хувцас нийлүүлэх 2023/46", "Ажилтнуудын хувцас ажлын хувцас нийлүүлэх 2023/52", "Хөдөлмөр хамгааллын өвлийн хувцас нийлүүлэх 2023/78", "Өвлийн гутал нийлүүлэх гэрээ 2023/79 тоот гэрээг тус тус хэсэгчлэн байгуулж, худалдан авалт хийж ажилласан байна.	1	81,628.0					1	81,628.0				
Тухайн онд худалдан авсан барааг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт гаргаагүй, "Сорос компьютер" ХХК-тай шууд гэрээ байгуулж компьютер тоног төхөөрөмж худалдан авсан байна	1	0					1	0				
Дүн	3	81,628.0					3	81,628.0				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Захиргааны шийдвэр гаргах, удирдах, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж шилэн дансанд мэдээлээгүй байна.	1	0					1	0
Нийт дүн	1	0					1	0